



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/15

Өвт

Цэргийн бүртгэл явуулах тухай.

Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 34 дүгээр зүйл, Аймгийн Засаг даргын 2021 оны Цэргийн бүртгэл явуулах тухай" А/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021 оны цэргийн бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 15-аас 2021 оны 01 дүгээр сарын 25-ны дотор зохион байгуулсугай.
2. Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.  
Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга  
Гишүүд: Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга  
Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга  
С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга  
Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга  
Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга  
Б.Орбиш - Нийгмийн ажилтан  
Г.Сарантуяа-Архив, бичиг хэргийн эрхлэгч  
Г.Дуламдорж-Насан туршийн боловсролын арга зүйч
3. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахдаа иргэдэд зар мэдээллийг хүргэн, иргэний цахим үнэмлэх, цэргийн үүрэгтний үнэмлэхийг үндэслэн бүртгэхийг багийн Засаг дарга (Т.Жамъянжав, Д.Даваацэрэн, С.Төмөр, Г.Пүрэвтогтох, Л.Балжинням) нарт даалгасугай.
4. Цэргийн бүртгэлийг Соёлын төвийн байранд заасан хугацаанд заавар журмын дагуу явуулж, дүн мэдээг 2021 оны 02 дугаар сарын 03-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабт хүлээлгэн өгөхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Бат- Эрдэнэ)-д даалгасугай.
5. Цэргийн бүртгэл зохион байгуулахад шаардагдах 300000 /Гурван зуун мянган/ төгрөгийг Засаг даргын нөөцөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

05 4 0100 < y